Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 тоот тушаалын
6 дугаар хавсралт

Түншлэлийн төслийн хэрэгжилт хяналт хариуцсан мэргэжилтэн, Лхагварэнцэн Сугар

## 2025 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

### НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1.1. Төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх төслийн урьдчилсан үнэлгээг хянан баталгаажуулах, төслийг хөгжлийн бодлогын баримт бичигт тусгах, төслийн бүрэн шинжилгээг хянах, дүгнэх, төслийн сонгон шалгаруулалт болон түншлэлийн гэрээ байгуулах ажлыг зохион байгуулах, түншлэлийн гэрээний биелэлтэд хяналт тавих, түншлэлээр хэрэгжсэн төслийг төрийн болон орон нутгийн өмчид шилжүүлэх, бүртгэх арга хэмжээг удирдан зохион байгуулах. | | | | | | | |
| 1 | Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг дагалдан гарах журам, аргачлалд заасны дагуу хэрэгжилтийг хангаж ажиллана. | Хэрэгжилтийн явц, хувиар | Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль батлагдсан. 2024 оны 01 сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. | Холбогдох журам, аргачлалд заасны дагуу хэрэгжилтийг хангаж ажилласан байна. /50 хувь/ | Монгол Улсын Их Хурлын 2024 оны 52 дугаар тогтоолоор Төр, хувийн хэвшлийн түншлэлийг дэмжих, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, уг хууль болон холбогдох журмыг хэрэгжүүлэх явцад үүсэж буй зарим хүндрэлтэй асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оны 02 дугаар сарын 19-ны өдрийн А/18 тоот тушаалаар ТХХТТХ-д өөрчлөлт оруулах, санал боловсруулах чиг үүрэг | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | бүхий аждын хэсэг байгуулагдаж хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл, үзэл баримтлал, дагалдах судалгааны ажлуудыг хийж гүйцэтгэн холбогдох яамдад хүргүүлж санал авах, нэмэлт, өөрчлөлтийн төсөл, холбогдох судалгаа, танилцуулгыг бэлтгэх ажилд удирдлагаас өгсөн үүргийн дагуу ажиллсан. | | |
| 2 | Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль болон тус хуулийг дагалдан гарсан журам, аргачлалын хүрээнд сургалтыг зохион байгуулна. | Зохион байгуулах сургалтын тоо | Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль батлагдсан. 2024 оны 01 сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. | Холбогдох байгууллагуудад нийт 3-аас доошгүй удаа сургалт орсон байна. | Төр, хувийн хэвшлийн түншлэлийн эрх зүйн орчин болон Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан түншлэлээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн талаар сурталчлах, танилцуулах, санал солилцож, хэлэлцэх зорилго бүхий "Төр, хувийн хэвшлийн түншлэлийн форум" 2025 оны 03 дугаар сарын 13-ны өдөр 200 албан хаагчид болон олон улсын байгууллага, хувийн хэвшлийн төлөөлөгчтэй зохион байгуулсан. Мөн Төр, хувийн хэвшлийн түншлэлийн олон улсын сертификат олгох (The APMG PPP Certification Program) сургалтыг 2025 | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | оны 7 дугаар сарын 1-4-ны өдрүүдэд танхимын хэлбэрээр зохион байгуулахаар ажиллаж байна. | | |
| 3 | Төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэхээр салбар яамдаас ирүүлсэн саналыг ТХХТ-ийн хуульд заасны дагуу судлан, холбогдох арга хэмжээг авч ажиллана. | Хэрэгжилтийн явц, хувиар | Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль батлагдсан. 2024 оны 01 сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. | Төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэхээр салбар яамдаас ирүүлсэн саналыг ТХХТ-ийн хуульд заасны дагуу судлан, холбогдох арга хэмжээг авч ажиллана. | Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг дагалдан нийт 9 журам, аргачлал 2023 онд батлагдсан. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн хүрээнд түншлэлээр төсөл хэрэгжүүлэхэд салбар яамнаас түншлэлийн төслийн саналыг ирүүлэх бөгөөд ийнхүү төслийн саналаа ирүүлэхдээ Засгийн газрын 2023 оны 404 дүгээр тогтоолоор батлагдсан "Төслийн бүрэн шинжилгээ хийх журам"-ын дагуу "Арцсуурь-Шивээхүрэн-Нарийнсухайт чиглэлийн 1255 км төмөр замын төслийн хүрээнд Шивээхүрэн-Нарийнсухайт-Шинэжинст чиглэлийн төмөр зам", "Мөрөн-Улиастай хүртэлх 261.65 км авто зам" төслүүдийн боловсруулж ирүүлсэн саналын дагуу ТХХТ-ийн тухай хууль болон журамд заасны дагуу урьдчилсан үнэлгээ хийгдсэн бөгөөд бүрэн | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | шинжилгээ хийх төслийн багийг байгуулж бүрэн шинжилгээ хийгдэж байна. | | |
| 4 | Концессын гэрээний хэрэгжилт, явц, үр дүнд хяналт тавин ажиллаж, холбогдох арга хэмжээг авч ажиллана. | Хэрэгжилтийн явц, хувиар | Концессын гэрээний хэрэгжилтийн явцад тухай бүр хяналт тавьсан. | Концессын гэрээний хэрэгжилт, явц, үр дүнд хяналт тавин ажиллаж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. | Концессын тухай хуулийн хүрээнд гэрээ байгуулагдан хэрэгжиж байгаа Тосонцэнгэлийн 4 замын уулзвар-Нөмрөг-Сонгино чиглэлийн 167 км хатуу хучилттай авто зам төсөл, Өмнөговь аймгийн төвийг нийслэлтэй холбосон авто замын “Шар тээг”-ийн уулзвараас Цогтцэций сумын төв хүртэлх 59.6 км хатуу хучилттай авто зам төсөл, Зорчигчийн хоол бэлтгэх зориулалт бүхий катерингийн барилгыг барьж, үйлчилгээ үзүүлэх төсөл, Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн авто зам төслүүдийн гэрээний хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж, тухай бүр холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна. Мөн Эдийн засаг, хөгжлийн яамны төрийн нарийн бичгийн даргын “Дотоод томилолтоор ажиллуулах тухай” 2025 оны 05 дугаар сарын 02-ний өдрийн А/124 дугаар тушаалын дагуу Тавантолгой-Манлай- | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Ханги чиглэлийн авто замын төслийг ашиглалтад авах эсэх шийдвэрийг гаргах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнд 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдрөөс 05 дугаар сарын 09-ний өдрийн хооронд ажиллаж тухайн авто замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулан хөдөлгөөнийг нээх шийдвэр ажлын хэсгээс гаргасан. | | |
| 5 | Хэрэгжилтийн явц, хувиар | Хэрэгжилтийн явц, хувиар | Монгол Улсын 2025 оны төсөвт 1 төслийн санхүүжилт батлагдсан. | Улсын төсөвт батлагдсан санхүүжилтийг хууль, гэрээ, аудитын дүгнэлтэд нийцүүлэн шийдвэрлэсэн байна. | Концессын "барих-шилжүүлэх" төрлөөс бусад төрлөөр хэрэгжиж буй "Тосонцэнгэлийн 4 замын уулзвар-Нөмрөг-Сонгино чиглэлийн 167 км хатуу хучилттай авто зам төсөл"-ийн концессын гэрээний эргэн төлөлтийн санхүүжилтийг олгож дууссан, "Өмнөговь аймгийн төвийг нийслэлтэй холбосон авто замын "Шар тээг"-ийн уулзвараас Цогтцэций сумын төв хүртэлх 59.6 км хатуу хучилттай авто зам төсөл"-ийн гэрээ дүгнэсэн дүгнэлт тооцоо нийлсэн актыг хийж баталгааны 5%-ийн санхүүжилт болон дутуу хийгдсэн ажлын үлдэгдэл, баталгаат | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хугацааны санхүүжилтийг олгохоор ажиллаж байгаа бөгөөд "Оюутолгой-Цагаан суварга чиглэлийн агаарын шугам, дэд станц төсөл"-ийн аудитын тайлан дүгнэлтэд тусгагдсан төслийн хэвийн ашиглалтад оруулахад зайлшгүй хийж гүйцэтгэх шаардлагатай хийгдээгүй, дутуу болон зөрчилтэй ажлыг бүрэн гүйцэд хийж холбогдох мэдээ тайланг ирүүлсний дараа уг төслийн 2023 оны Улсын төсөвт батлагдсан санхүүжилтийг шийдвэрлэхээр ажиллаж байна. Монгол Улсын 2025 оны төсөвт батлагдсан "барих-шилжүүлэх" төрлийн концессын гэрээний санхүүжилт байхгүй бөгөөд хариуцан ажилладаг төслүүдийн гэрээний хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж, тухай бүр холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна. | | |
| 6 | Нэгжийн эрхлэх чиг үүргийн хүрээний асуудлаар Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төвийн үйл ажиллагааг | Хэрэгжилтийн явц, хувиар | - | Төвийн үйл ажиллагааг бодлогоор зохицуулах, чиглүүлэх, хяналт тавив ажлыг | Салбар яамдаас ирүүлсэн түншлэлийн төслийн саналыг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль болон дагалдан гарсан журам, | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | бодлогоор зохицуулах, чиглүүлэх, хяналт тавих Эрэмбэ 7 | | | хэрэгжүүлсэн байна. | аргачлал заасны дагуу хүлээн авах, урьдчилсан болон бүрэн шинжилгээний багийн бүрэлдэхүүнд орж ажиллаж байна. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль, холбогдох журмын талаар төрийн байгууллагууд, аж ахуйн нэгжүүдийн зарим албан тушаалтнуудад тогтмол мэдээллийг хуулийн хүрээнд өгч ажиллаж байна. | сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | |

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

| № | Үүрэг даалгавар | Өгсөн субъект | Биелэлт |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дууссан хугаца | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх | | | | | | | |
| 1 | Хариуцсан чиг үүргийн хүрээнд сургалт, семинар, хэлэлцүүлэгт оролцсон байна. | Сургалт, семинар, хэлэлцүүлэгт оролцох. | - | Сургалт, семинар, хэлэлцүүлэгт оролцсон байна. /100 хувь/ | Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасаны дагуу мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлж байна. | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2 | Яамнаас зохион байгуулсан мэдээллийн цагт тогтмол оролцсон байна. | Мэдээллийн цагт тогтмол оролцох. | - | Мэдээллийн цагт тогтмол оролцсон байна. /100 хувь/ | Яамнаас зохион байгуулсан мэдээллийн цагт тогтмол оролцож хувь хүний хөгжил болон өөрийн сонирхсон чиглэлээр мэдлэг чадвараа хөгжүүлж байна. | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

ТАЙЛАНТАЙ ТАНИЛЦСАН:

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлтсийн дарга: О.Мөнхтөр /......................................................../ Огноо: 2025.06.25

ТАЙЛАН ГАРГАСАН:

Түншлэлийн төслийн хэрэгжилт хяналт хариуцсан мэргэжилтэн, Лхагварэнцэн Сугар /....................................../ Огноо: 2025.06.25

ТҮ32561 6806236 9022010236